



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/589

Номгон

Г
Орон нутгийн хамгаалалтын томилгоот
нэгжийн удирдах бүрэлдэхүүнтэй сургалт
зохион байгуулан явуулах тухай

“Батлан хамгаалах тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, “Орон нутгийн хамгаалалт”-ын тухай хуулийн 09 дүгээр зүйлийн 9.3, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.4.1, 2015 оны Монгол Улсын Их хурлын Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс батлах тухай 85 дугаар тогтоолын 2.3.3 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор баталсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах” журмын 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 16-18-ны өдрүүдэд Баянговь, Баянлиг сумдад зохион байгуулж явуулсугай.

2.Сургалтыг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулж, дүнг илтгэхийг Цэргийн штаб (хурандаа Г.Нэмэхбаяр)-д үүрэг болгосугай.

3.Сургалтад шаардагдах 3,418,520 (Гурван сая дөрвөн зуун арван найман мянга таван зуун хорин) төгрөгийг Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын орон нутагт үлдэх хэсгээс зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

842311559

Аймгийн Засаг даргын ... оны ... дүгээр
сарын ... -ны өдрийн ... дүгээр захирамжийн

хавсралт

ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Зардлын тооцоо		
		Тоо	Нэг бүрийн дүн	Нийт дүн
1	Сургалтад хамрагдах бүрэлдэхүүний хоолны зардал	300 хүн	12.000 төг	2.700.000 төг
2	Шатахуун	284 л	2530 төг	718.520 төг
Дүн		3,418,520 төг		

оОо